

Аврахаам эцэг

1-р хичээл

Аврахаамын амьдрал: Бүтэц ба
Агуулга
(Пентатекийн 6-р хичээл)

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2012 Гуравдахь мянган жил үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Энэхүү материалыг 2007 онд Ийгли ТВ-н Христийн Нэвтрүүлгийн албанд орчуулсан бөгөөд Библийн зарим эшлэлүүдийг Монголын Библийн Нийгэмлэгийн Шинэ Гэрээ ©1990 Эхлэл, номноос зохиогчийн зүгээс Ийгл ТВ-ын Христийн нэвтрүүлгийн албанд өгсөн зөвшөөрлийн дагуу оруулсан.

Библийн бусад эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи ©2004-ээс авлаа.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛ нь 1997 онд ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН, АШГИЙН БУС, ХРИСТИТГЭЛИЙН САЙНМЭДЭЭНИЙ ҮЙЛЧЛЭЛ БӨГӨӨД ДАРААХ ТАЛБАНУУДАД ЧИГЛЭДЭГ:

БИБЛИЙН БОЛОВСРОЛЫГ. БҮХ ДЭЛХИЙД. ҮНЭГҮЙ.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид теологийн мэргэжлийн сургагч багш нар байдаг бөгөөд орчуулагчид нь орон нутгийнхаа унаган хэлтэй теологийн мэдлэгтэй хүмүүс байдгаараа давуу талтай. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <https://www.thirdmill.org> цахим хуудсаар зочлоорой.

Аврахаамын амьдрал:

Нэгдүгээр хичээл

Бүтэц ба Агуулга

Агуулга

Удиртгал	1
Утга зохиолын зохиомж	2
Эхлэл	2
Аврахаам	3
Үндсэн хэсгүүд	3
Цэгцэрсэн хэсгүүд	5
Үндсэн сэдвүүд	7
Түлхүүр ишлэлүүд	8
Танилцуулга	8
Эхний хэсэг	9
хоёрдахь хэсэг	10
Ил болсон хэсгүүд	11
Ертөнцийн Эзэний хайр өршөөл	11
Аврахаамын үнэнч байдал	12
Аврахаамд өгсөн сайн сайхан зүйлс	14
Аврахаамаар дамжин ирэх сайн сайхан зүйлс	15
ДҮГНЭЛТ	16
ҮГСИЙН ТАЙЛБАР	18

Аврахаамын амьдрал:

Нэгдүгээр хичээл

Бүтэц ба Агуулга

УДИРТГАЛ

Дэлхийн улс үндэстэнүүдийн хооронд маш их ялгаа байдгийг бид бүгд мэднэ. Тэд бүгд өөр өөрсдийн гэсэн газарзүйн байршилтай, өөр хоорондоо ялгаатай угсаатны бүлгүүдтэй, өвөрмөц уламжлал соёлтой байдаг. Гэхдээ ихэнхи улс орон хоорондоо нэг зүйлээр адил байдаг билээ. Бид бүгд улс үндэстэн маань анх хэрхэн бий болсон тухай түүхтэй. Бидний олонхи нь улс орныг маань үүсгэн бий болгосон хүмүүсийн гаргасан золиос, тэдний хүрсэн ололт амжилтын талаар сонсох дуртай байдаг. Бид тэдний баатарлаг үйлсийг магтан дуулдаг.

Тэгвэл бид яагаад гарал үүслийнхээ тухай түүхийг эрхэмлэн дээдэлж, бусдад ярьж өгдөг юм бэ? Яагаад энэ нь улс үндэстэн бүрийн соёлд тийм чухал байдаг вэ?

Үүнд дор хаяж хоёр шалтгаан байна. Нэг талаар бид өнгөрсөн үеийнхээ тухай дурсамжийг уламжлуулах гэж улс үндэстэнийхээ үүсэл гарлыг бусдад ярьдаг юм. Бид үр хүүхдүүдээ уг гарлаа, хаанаас ирсэнээ мэдэж байхыг хүсдэг. Нөгөө талаар бид улс үндэстэнийг маань удирдан жолоодож байсан үнэт зарчмуудыг санан дурсаж түүнээсээ ирээдүйн чиг баримжаагаа авахыг хүсдэг юм.

Хуучин Гэрээний үед амьдарч байсан Ертөнцийн Эзэний хүмүүс ч гэсэн бас ийм байсан. Эртний Израйльчууд өөрсдийнхөө хэрхэн бий болсон түүхийг эрхэмлэн хүндэтгэж, дээрх хоёр шалтгааны адил үеэс үед дамжуулдаг байлаа. Тэд өвөг дээдсийнхээ амьдарч байсан үеийн тухай дурсан ярьдаг байв. Тийм учраас өнгөрсөн үед болж өнгөрсөн агуу ололт амжилт мартагддаггүй байжээ. Тэд бас иймэрхүү түүхийг үеэс үед дамжуулсанаараа ирээдүйд явах чигээ өөрсөддөө сануулж байдаг юм.

Энэ бол “Аврахаам эцэг” гэдэг цувралын маань эхний хичээл юм. Бид энэ цуврал хичээлээр өөрсдийнхөө агуу өвөг болох Аврахаамын тухай эртний Израйльчуудын өгүүлсэн түүхийг судлах болно. Мөшөх энэ бүх түүхийг “Эхлэл” номонд бичсэн. Ингэснээр өөрийнх нь амьдарч байх үеийн Израйльчууд өнгөрсөн түүхээ мэдэж авна. Мөн ирээдүйд Ертөнцийн Эзэн тэдэнд зориулж юу хадгалж байгааг илүү сайн ойлгох болно.

Энэ бол тус цуврал гурван хичээлийн эхний хичээл юм. Бид энэ хичээлийг “Аврахаамын амьдрал: Бүтэц ба агуулга” гэж нэрлэлээ. Энэ хичээлээр бид Аврахаамын тухай өгүүлсэн “Эхлэл” номын хэдэн бүлгийн бүтэц болон агуулгад анхаарлаа хандуулан түүний амьдралыг ерөнхийд нь тоймлон судалж эхэлнэ. Мөшөх өөрийн тэмдэглэлдээ Аврахаамын амьдралыг хэрхэн оруулсан бэ? Эдгээр бүлгийн гол санаа юу байв?

Бид Аврахаамын амьдралыг өгүүлсэн эдгээр бүлгийн бүтэц болон агуулгыг хоёр хэсэг болгон үзнэ: Нэгдүгээрт, бид энэ материалын утга зохиолын зохиомжийг нь судлана. Хоёрдугаарт, бид эдгээр бүлгийн үндсэн сэдвүүдийг судлана. За одоо бүгдээрээ эхлээд Аврахаамын амьдралыг өгүүлсэн бүлгүүдийн утга зохиолын зохиомжийг үзэцгээе.

УТГА ЗОХИОЛЫН ЗОХИОМЖ

Бид Аврахаамын амьдралтай адилхан гол төлөв хүүрнэл болон үйл явдлаас бүрдсэн ариун бичээсийн хэсгүүдэд хандахдаа Библийн зохиогчид нь бидэнд зөвхөн олон жилийн өмнө болсон явдлын тухай үнэнээс илүү ихийг хэлсэн гэдгийг үргэлж санаж байх хэрэгтэй. Яагаад гэвэл Ариун Сүнс тэд нараар Ертөнцийн Эзэнийг төлөөлөн яриулж байгаа тул тэдний өгүүлж буй түүх нь бүхэлдээ үнэн байдаг. Мөн Ариун Сүнс тэднийг өөрсдийн хандан буй хүмүүсийн хэрэгцээний талаар бичүүлсэн. Тэгэхлээр Библийн зохиогчид уншигчидаа сэтгэлдээ тунгаан бодож байгаад түүхэн үйл явдлын тухай бичсэн ажээ. Тэд өгүүлж буй үйл явдлаа зориуд ингэж зохиомжлон оруулж өгсөн учраас тэр бүх түүх нь тэдний бичсэн зүйлийг хүлээн авч буй хүмүүсийн амьдралтай холбоотой байсан юм.

Тиймээс бид “Эхлэл” номонд өгүүлсэн Аврахаамын амьдралын тухай тэмдэглэлд хандахдаа энэ бүх түүх нь Аврахаамын амьдралд бодитой болсон үйл явдлыг буруу ташаа мэдээлээгүй гэдэгт баттай итгэж болно. Харин бид энэ бүх түүх нь Мөшэхийн анхны уншигчдын амьдралд хэрхэн хэрэгжиж байсныг мэдэхийн тулд “Эхлэл” номонд Аврахаамын амьдралыг хэрхэн дүрсэлж байгааг ойлгох хэрэгтэй. Аврахаамын амьдралыг хэрхэн дүрсэлж байгааг ойлгох нэг гол арга бол түүний амьдралын тухай өгүүлсэн “Эхлэл” номын бүлгүүдийн утга зохиолын зохиомжийг нь судлах явдал юм.

Бид Аврахаамын амьдралыг өгүүлсэн бүлгүүдийн утга зохиолын зохиомжийг хоёр үе шаттай судлана. Эхлээд бид “Эхлэл” номын тоймтой бүхэлд нь танилцаж, үүнд өгүүлэх ерөнхий том хэсэгт Аврахаамын амьдралын түүх хэрхэн багтаж байгааг харна. Хоёрдугаарт, бид Аврахаамын амьдралыг голчлон үзүүлсэн үйл явдлуудын бүтцийг судлана. Одоо бүгдээрээ “Эхлэл” номын ерөнхий тоймыг судалж эхэлцгээе.

ЭХЛЭЛ

Зуун зууны турш Библийн тайлбарлагчид Эхлэл номын ерөнхий бүтцийг янз бүрийн байдлаар ойлгож байв. Тэдний нэг нь Эхлэл номын турш давтагдан гарах Еврей хэлээр “толодот” буюу “үеүд” гэсэн утгатай арван үечилсэн хэсгээр үүнийг хуваах арга юм. Иймэрхүү өргөн хэмжээнд авч үзэх хандлага нь зарим талаар ач холбогдолтой байдаг гэдгийг бид хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Харин бид Эхлэл номыг гурван том хэсэгт хуваах нь илүү ашиг тустай гэж үзсэн өөр нэг аргачлалыг санал болгож байна. Эдгээр нь, Эхлэл номын 1-р бүлгийн 1-ээс 11-р бүлгийн 9 хүртэлх хэсгийг хамарсан Балар эртний түүх. 11-р бүлгийн 10-аас 37-р бүлгийн 1 хүртэлх хэсгийг хамарсан Эхэн үеийн Өвөг дээдсийн түүх болон, 37-р бүлгийн 2-оос 50-р бүлгийн 26-р ишлэлийг хамарсан Хожуу үеийн Өвөг дээдсийн түүх зэрэг юм.

Эхлэл номын 1-р бүлгийн 1-ээс 11-р бүлгийн 9 хүртэлх хэсгийг хамарсан Балар эртний түүх нь хүн төрөлхтний үүслийн тухай Ертөнцийн Эзэний илчилсэн үнэнийг танилцуулдаг. Энэ түүх нь орчлон ертөнцийг хэрхэн бүтээсэн, хүн төрөлхтөн гэмд унасан болон дэлхийг хамарсан усан галаваар бүх бүтээлийг хэрхэн дахин шинэчилсэн тухай өгүүлдэг. Мөн энэ бүх үйл явдал нь утга зохиолын нэгж хэсэг болж хоорондоо холбогдсон нь эртний ойрх дорнодын балар цагийн олон түүхийн загвартай их төстэй

байдаг юм.

Харин 37-р бүлгийн 2-оос 50-р бүлгийн 26-р ишлэлийг хамарсан Хожуу үеийн Өвөг дээдсийн түүх нь Юусээфийн амьдралыг өгүүлдэг. Энэ нь Юусээф болон түүний ах нарын хоорондох зөрчлөөр эхэлдэг. Цааш нь Юусээф Египетэд аажмаар эрх мэдэлтэй болж байгаа тухай өгүүлнэ. Эцэст нь Юусээф ах нартайгаа эвлэрч байгаа тухай гардаг. Энэ хоорондоо холбоотой дараалсан үйл явдлуудыг Юусээфийн тухай бэсрэг роман гэж Библийн олон тайлбарлагч тодорхойлсон байдаг юм.

Эдгээр эхний болон сүүлчийн хэсгийн дунд Эхлэл номын 11-р бүлгийн 10-аас 37-р бүлгийн 1 хүртэлх хэсэг оршдог. Энэ хэсэгт эхэн үеийн Өвөг дээдсийн түүхийг өгүүлдэг. Өөрөөр хэлбэл энэ бол Израйль үндэстэний анхны өвөг дээдсийн тухай өгүүлсэн эмхэтгэл юм. Бид энэ цуврал хичээлээрээ Эхлэл номын дундах ганцхан хэсгийг л үзэх болно.

Ерөнхий утгаар нь авч үзвэл, эхэн үеийн Өвөг дээдсийн түүхийг 2 хэсэгт хуваадаг. Эдгээр нь 11-р бүлгийн 10-аас 25-р бүлгийн 18 хүртэлх хэсгийг хамарсан Аврахаамын амьдрал, 25-р бүлгийн 19-ээс 37-р бүлгийн 1-ийг хамарсан Яаховын амьдрал юм. Гэхдээ ингэж хоёр хэсэгт хуваасан нь таныг жаахан гайхшруулж байж магадгүй. Учир нь бид библиэс Аврахаам, Яйцхаах, Яахов гэсэн эртний гурван өвөг дээдсийн нэрийг олонтоо сонсдог билээ. Тиймээс бид өөрийн эрхгүй эдгээр бүлгийн утга зохиолын бүтцийг гурав хувааж авч үзэх гээд байдаг. Энэ нь бидэнд эхлээд Аврахаамын тухай, дараа нь Яйцхаахын тухай, тэгээд Яаховын тухай өгүүлдэг гэж боддог. Үнэнийг хэлэхэд эртний өвөг дээдсийн тухай өгүүлсэн Эхлэл номын ямар ч хэсэгт Яйцхаахыг гол дүрийн нэг гэж харуулдаггүй. Үүний оронд түүнийг зөвхөн шилжилтийн дүр болгож харуулдаг. Түүний амьдралыг эхлээд Аврахаамын амьдралын нэг хэсэг болгож өгүүлж байгаад, дараа нь Яаховын амьдралын нэг хэсэг болгож гаргадаг. Үүний үр дүнд эхэн үеийн өвөг дээдсийн түүх нь хоёр гол хэсэгт хуваагддаг. Эхнийх нь Аврахаамын амьдрал, дараагийнх нь Яаховын амьдрал юм. Бид энэ цуврал хичээлээр өвөг дээдсийн түүхийн эхний хагас буюу Аврахаам эцгийн тухай өгүүлсэн Мөшэхийн тэмдэглэлийг үзэх болно. За одоо бүгдээрээ Эхлэл номын 11-р бүлгийн 10-аас 25-р бүлгийн 18-д танилцуулсан Аврахаамын амьдралыг өгүүлсэн хэсгийн бүтцийг илүү нарийвчлан үзэцгээе.

АВРАХААМ

Бид Эхлэл номын ерөнхий бүтцэд Аврахаамын амьдрал хаана нь багтаж орсоньг харсан. Харин одоо бид Эхлэл номын 11-р бүлгийн 10-аас 25-р бүлгийн 18-д Аврахаамын амьдралын бүрдэл хэсгүүд ямар байдлаар орж байгааг үзэх болно. Бид Аврахаамын амьдралын бүрдэл хэсгүүдийг судлахдаа Эхлэл номын эдгээр бүлгийг хоёр түвшинд авч үзнэ. Нэг талаар бид Аврахаамын амьдралын үндсэн хэсгүүд буюу үйл явдлыг ялгаж тогтооно.

Үндсэн хэсгүүд

Мөшгэх Аврахаамын амьдралын 17 бие даасан хэсэг буюу үйл явдлын тухай бичсэн байдаг:

1. Нэгдүгээрт, Аврахаамын таалалд нийцсэн угсаа гаралыг 11-р бүлгийн 10-аас 26-д бичсэн. Энэ угийн бичигт Аврахаамын гэр бүлийн өвийг тодорхойлжээ.
2. Энэ хэсгийн дараа Аврахаамын зорилгодоо хүрээгүй эцгийн тухай 11-р бүлгийн 27-оос 32-р ишлэлд өгүүлдэг. Аврахаамыг эцэг Тираахын хамт Хинаан нутаг уруу явж байгаа тухай өгүүлэхдээ түүний хоёр дахь угийн бичгийг дурддаг.
3. Харин 12-р бүлгийн 1-ээс 9-д Аврахаам Хинаан нутаг руу нүүж байгаа тухай өгүүлнэ. Энд мөн Мөнхийн Эзэн Аврахаамыг анх удаа дуудаж байгаа болон Түүний амласан нутаг руу явж байгаа түүх гарна.
4. Цааш нь 12-р бүлгийн 10-аас 20-д Аврахаам Египетээс аврагдан гарсан тухай өгүүлдэг. Энэ бол Аврахаам Египет нутгаар хэрэн хэсэж байгаа болон Ертөнцийн Эзэн түүнийг чөлөөлж буй үе юм.
5. Тэгээд 13-р бүлгийн 1-ээс 18-д Аврахаам Лооттой зөрчилдөж байгаа тухай гарна. Энд мөн Аврахаам болон Лоотын зарц нарын хоорондын маргааныг өгүүлдэг.
6. Аврахаам Лоотыг аварч байгаа тухай 14-р бүлгийн 1-ээс 24-т өгүүлдэг. Энэ бол Аврахаам Лоотыг олзлон авсан хаадтай түүнийг суллахын тулд дайтаж байгаа үе юм.
7. Харин 15-р бүлгийн 1-ээс 21-д Аврахаамтай тогтоосон гэрээний амлалтыг өгүүлдэг. Мөнхийн Эзэний Аврахаамтай байгуулсан гэрээ нь түүнийг үй олон удамтай, үргэлж оршин суух нутагтай болохыг батлан хэлдэг.
8. Аврахаам Хагаар хоёрын бүтэлгүй харилцааны тухай 16-р бүлгийн 1-ээс 16-д өгүүлнэ. Энэ бол Аврахаам эхнэр Сарайгийнхаа зарц Хагаараас Яйшмагийл гэдэг хүүтэй болсон үе юм.
9. Харин 17-р бүлгийн 1-ээс 27-д Аврахаамтай тогтоосон гэрээний нөхцөлийг бичсэн. Аврахаам Ертөнцийн Эзэний тушаалыг үнэнчээр дагах нь зайлшгүй чухал болох талаар Түүний гэрээний энэ хэсэгт өгүүлдэг.
10. Сидом, Гомораах хотын тухай 18-р бүлгийн 1-ээс 19-р бүлгийн 38 хүртэл гарна. Энд Сидом, Гомораах хотын сүйрэл болон энэ сүйрлээс Лоотыг аварсан тухай өгүүлдэг.
11. Аврахаам Аби-Мэлэхийн төлөө Ертөнцийн Эзэнээс гуйсан тухай 20-р бүлгийн 1-ээс 18-д өгүүлдэг. Энэ бол Филистчүүдийн хаан Аби-Мэлэхийн төлөө Аврахаам Ертөнцийн Эзэнтэй ярьсан үе билээ.
12. Аврахамын хүүхдүүд болох Яйцхаах, Яйшмагийл нарын тухай 21-р бүлгийн 1-ээс 21-т гарна. Яйцхаах төрсөн болон Яйшмагийлыг Аврахаамын гэр бүлээс хөөсөн үйл явдлыг энд өгүүлдэг.
13. 21-р бүлгийн 22-оос 34-т Аврахаам Аби-Мэлэхтэй гэрээ байгуулж байгаа тухай гарна. Энэ бол Аврахаам газар нутаг, худаг ус ашиглах эрхийн талаар Аби-Мэлэхтэй гэрээ байгуулсан үе юм.

14. Аврахаамыг сорьсон тухай 22-р бүлгийн 1-ээс 24-т өгүүлдэг. Энэ бол Ертөнцийн Эзэн Аврахаамыг хүү Яйцхаахаа өөрт нь өргөл болгохыг тушаасан үе юм.
15. Аврахаамын оршуулгын өмч газрын тухай 23-р бүлгийн 1-ээс 20-д өгүүлдэг. Энэ нь Сараах нас барсан болон оршуулгын газар худалдаж авсан түүх юм.
16. Аврахаамын хүү Яйцхаахад эхнэр олж өгсөн тухай 24-р бүлгийн 1-ээс 67-д өгүүлнэ. Энэ бол Ривхаах Яйцхаахын эхнэр болсон үе юм.
17. Эцэст нь Аврахаам нас барсан болон түүний өв залгамжлалын талаар 25-р бүлгийн 1-ээс 18-д өгүүлнэ. Үүгээр Аврахаам өөд болж байгаа болон түүний үр удмын тухай түүх дуусгавар болдог.

Тэгэхлээр сая бид Аврахаамын амьдралын түүх нь түүнд тохиолдсон үйл явдлын үндсэн дарааллыг дагаж байгааг үзлээ. Энэ бүхэн эцгийнхээ захиргаанд буй нэлээд залуухан хархүүгийн амьдралаар эхэлж, насан өндөр болсон Аврахаам нас барж байгаагаар төгсөж байна. Аврахаамын амьдралын янз бүрийн үйл явдлуудын хооронд үл мэдэг, битүүхэн холбоо байдаг ч Хуучин Гэрээний бусад хэсэгтэй харьцуулахад Аврахаамын амьдралын түүх нь харьцангуй бие даасан 17 цуврал хэсгээс бүрддэг юм. Эдгээр хэсэг тус бүр нь Аврахаамын амьдралд тохиолдсон үйл явдлыг мэдээлэх болон Мөшэхийн энэ номын анхны уншигч болох Израйльчуудад тусгай хичээл заах зорилготой байлаа. Тэднийг Мөшэх Ертөнцийн Эзэний амласан нутагт удирдан аваачихад дээрх 17 цуврал хэсэг тус бүр маш их ач холбогдолтой байв. Эдгээр нь өнөөгийн бидний амьдралд ч гэсэн ач холбогдолтой хэвээр байна.

Бид Аврахаамын амьдралын үндсэн хэсэгтэй танилцсан болохоор одоо энэ бүхэн хоорондоо хэрхэн холбогдож байгаа судлах боломжтой боллоо. Тэгэхлээр Аврахаамын амьдралын үйл явдлууд хоорондоо хэрхэн нэгдэж байна вэ? Ямар уялдаа холбоо энэ бүхнийг зохицуулж байна вэ? Энгийнээр хэлэхэд Аврахаамын амьдралд өрнөн буй үйл явдлууд нь тодорхой сэдвүүдийг тойрон эргэлдэж байв. Энэ бүхэн нь таван тэгш хэмт буюу тэнцвэртэй үе шатаас бүрддэг.

Цэгцэрсэн хэсгүүд

Мөшэх Израйль үндэстэний өвөг дээдэс болох Аврахаамын амьдралыг түүний уг гарал болон Ертөнцийн Эзэнтэй харилцсан анхны харилцааг нь бичиж эхэлдэг. Энэ хэсэгт Аврахаамын таалалд нийцсэн угсаа гарал, зорилгодоо хүрээгүй эцэг болон Хинаан руу нүүсэн зэрэг нь ордог. Энэ хэсэгт Аврахаам хэрхэн Ертөнцийн Эзэнтэй тусгай харилцаа үүсгэж байгааг түүний уг гарал болон Амласан нутаг уруу явсан эхний нүүдэл зэрэгт гол анхаарлаа хандуулан тайлбарладаг.

Аврахаамын амьдралд тохиолдсон хоёр дахь бүлэг үйл явдлууд нь бусад хүмүүстэй харилцсан түүний эхний харилцаан дээр төвлөрдөг. Энэ тухай 12-р бүлгийн 10-аас 14-р бүлгийн 24-д өгүүлдэг. Энэ хэсэгт түүний Египетээс аврагдсан гарсан, Лооттой зөрчилдсөн болон Лоотыг аварсан үйл явдлууд багтдаг. Энэ гурван үйл явдал нь Аврахаамыг янз бүрийн бүлэг хүмүүсийн төлөөлөлтэй уулзаж тэдэнтэй харилцаж байгаад гол анхаарлаа хандуулдаг учраас цугтаа ордог юм. Эдгээр бүлэгт Аврахаам

Египетийн хаантай зөрчилдсөн асуудлаа шийдэж, ач дүү Лоот болон түүнийг олзолсон хаадтай байлдаж, Сидом хотын хаан болон Шалээм хотын хаан Малхи-Цэдээхтэй уулзаж байгааг голлон үзүүлдэг.

Аврахаамын амьдралд тохиолдсон гурав дахь бүлэг үйл явдал буюу гол хэсэг нь түүний Ертөнцийн Эзэнтэй тогтоосон гэрээний харилцаан дээр төвлөрдөг. Энэ тухай 15-р бүлгийн 1-ээс 17-р бүлгийн 27-д өгүүлдэг. Израйльчуудын алдартай өвгийн амьдралын энэ хэсэг нь, Ертөнцийн Эзэний тогтоосон гэрээний амлалтууд, Хагаартай бүтэлгүйтсэн харилцаа болон уг гэрээний нөхцөл гэсэн гурван үйл явдлаас бүрддэг.

18-р бүлгийн 1-ээс 21-р бүлгийн 34-г гарах Аврахаамын амьдралын дөрөвдэх бүлэг үйл явдалд түүний бусад хүмүүстэй харилцсан хожуу үеийн харилцаа багтдаг. Бусад хүмүүстэй Аврахаам хэрхэн харилцаж байгааг голчлон үзүүлдэг учраас эдгээр бүлгийг цугт нь авч үздэг. Энд Сидом, Гомораах хотынхонтой Аврахаам хэрхэн харилцаж байгаа үзүүлжээ. Мөн бид Аврахаам Аби-Мэлэхийн төлөө зуучлан гуйсныг, Яйцхаах Яйшмагийл хоёртой хэрхэн харилцсаныг болон Аби-Мэлэхтэй гэрээ байгуулсан тухай уншдаг. Энэ дөрвөн бүлэг үйл явдал нь Израйльчуудын өвөг Аврахаам нь Лоот болон түүний гэр бүл, Сидом, Гомораах хотынхон, Пилэшэт аймгийн хаан Аби-Мэлэхтэй хэрхэн харилцаж байсныг харуулдаг.

Бид Аврахаамын амьдралын хамгийн сүүлчийн хэсэг буюу тав дахь бүлэг үйл явдлыг 22-р бүлгийн 1-ээс 25-р бүлгийн 18 хүртэл хэсгээс харж болох юм. Энд Аврахаамын амьдралын төгсгөл хэсгийг өгүүлдэг. Ялангуяа түүний бусад хүүхдүүд болон нас барсан тухай гардаг. Аврахаам оршуулгын газар худалдаж авсан, хүүдээ хэрхэн эхнэр олж өгсөн тухай өгүүлдэг. Мөн энэ хэсэгт Аврахаам өөд болсон тухай гардаг. Эдгээр бүлэгт Аврахаамын эхнэр Сараах болон түүний жинхэнэ өв залгамжлагч Яйцхаахыг Аврахаамын бусад эхнэр, хүүхдүүдээс нь илүү өндөрт өргөж байгааг голчлон өгүүлдэг.

Аврахаамын амьдралд тохиолдсон эдгээр үйл явдал нь бие биенээсээ харьцангуй бие даасан шинжтэй байдаг учраас хүмүүст Аврахаамын тухай анх удаа унших үед нэг үйл явдлаас нөгөө үйл явдал уруу үсрэн орж ямар ч зорилгогүйгээр хэсээд байгаа мэт мэдрэмж төрдөг байна. Тэд Аврахаамын тухай энэ бүх түүхийг уншиж байхдаа Мөшэх урьдчилан нэг их сайн төлөвлөлгүйгээр нэг үйл явдлын тухай дурдаж байснаа огт өөр үйл явдал руу халтиран орж байгаа мэтээр боддог. Иймэрхүү анхны сэтгэгдлийг үл харгалзан авч үзвэл Аврахаамын амьдралын түүх нь үнэндээ бол гол сэдвүүдийг тойрон эргэлдэх хэд хэдэн бүлэг үйл явдлаас бүрддэг юм. Бидний хэрэглэж буй энэ таван үе шат бүхий энгийн тойм нь Аврахаамын тухай юу гэж хэлэхээ Мөшэх урьдчилан төлөвлөсөн гэдгийг илчлэн харуулдаг. Аврахаамын амьдралын тухай тэмдэглэлийг бүхэлд нь авч үзвэл хоорондоо агуулга болон хэмжээгээрээ ойролцоо үйл явдлуудаас бүрдсэн нэг л түүх гардаг. Энэ түүхийг бүрдүүлж буй хэсэг бүр нь хоорондоо тэнцвэртэй харьцаанд байдаг.

Бид 11-р бүлгийн 10-аас 12-р бүлгийн 9-д Аврахаамын гэр бүлийн уг гарал болон түүний Ертөнцийн Эзэнтэй тогтоосон эхний харилцаан дээр гол анхаарлаа хандуулсан байгааг хардаг. Харин энэ эхний хэсэгтэй сөргүүлэн 22-р бүлгийн 1-ээс 25-р бүлгийн 18-д Аврахаамын амьдралын сүүлчийн он жилүүд болон үр хүүхдүүдийнх нь тухай дурдаж энэ хоёр хэсгээ тэнцвэржүүлж байна.

Харин Аврахаамын амьдралын хоёрдахь хэсэг нь гол төлөв бусад овог аймаг,

үндэстэний хүмүүстэй түүний харилцсан харилцааг тодорхойлсон үйл явдлуудаас бүрддэг. Тэгэхлээр энэ хоёрдахь хэсэгт гарч буй үйл явдлуудыг хоорондоо ижил төстэй ерөнхий түүхтэйгээ холбож үзвэл Аврахаамын амьдралын дөрөвдэхь хэсэгт бусад хүмүүстэй харилцсан жишээ илүү түлхүү орсон байдаг.

Эцэст нь Аврахаамын амьдралын оргил үеийг өгүүлсэн 3 гол бүлэгт Ертөнцийн Эзэний түүнтэй тогтоосон гэрээг чухалчлан өгүүлдэг. Энэ 3 бүлэг нь Аврахаамын амьдралын чухал үеийг тодорхойлдог бөгөөд түүний болон үр удмынх нь Ертөнцийн Эзэнтэй тогтоосон гэрээний харилцааны гол хөдөлгөгч хүчийг тайлбарладаг.

Эдгээр бүлгийн ерөнхий бүтэц нь Мөшэх энэ номыг тун хягуур бодож бичсэнийг илчлэн харуулдаг юм. Тэрбээр Израйльчуудын анхны алдартай өвгийнхөө амьдралын зарим хэсэгт уншигчдын анхаарлыг хандуулж түүний утга зохиолын дүр төрхийг бий болгож байна. Ертөнцийн Эзэн Аврахаамыг ивээхээр сонгон авч байгаа болон Аврахаамын жинхэнэ өв залгамжлагч хэн болох, эсвэл түүний бусад хүмүүстэй харилцсан эхний болон хожмын харьцаа, түүний Ертөнцийн Эзэний тогтоосон гэрээний харилцаа гэх мэт. Тэгэхлээр Мөшэх өөрийнхөө анхны уншигчид болох Израйльчуудынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэхийн тулд утга зохиолын ийм хэлбэрт анхаарлаа хандуулсан юм байна гэдгийг бид олж харна. Аврахаамын амьдрал нь Израйльчуудад Мөшэх тэднийг Ертөнцийн Эзэний амласан нутаг уруу удирдан дагуулж явахад тэд хэрхэн Аврахаамын үлгэр жишээг дагахыг зааж өгч байлаа. Тиймээс бид Эхлэл номын энэ хэсгийг судалж байхдаа үүнийг зориуд ийм зохиомжоор бичсэн нь ямар их ач холбогдолтой болохыг дахин дахин харах болно.

Ийнхүү бид Аврахаамын амьдралыг өгүүлсэн бүлгүүдийн утга зохиолын ерөнхий зохиомжийг үзлээ. Одоо бүгдээрээ Аврахаамын амьдралыг өгүүлсэн бүлгүүдийн бүтэц ба агуулга гэсэн энэ хичээлийнхээ хоёр дахь хэсгийг үзнэ. Энэ бол 11-р бүлгийн 10-аас 25-р бүлгийн 18-д буй үндсэн сэдвүүд юм. Хэдийгээр эдгээр бүлгийн агуулгыг олон аргаар тодорхойлж болох ч, бидний санал болгож буй тойм нь үндсэн гол сэдэвтэйгээ нэлээд холбогдож байгааг та бүхэн харах болно.

ҮНДСЭН СЭДВҮҮД

Ертөнцийн Эзэний сургаалаас Аврахаамын амьдрал шиг олон бүлгийг хамарч орсон цогц хэсгийн гол санааг тодорхойлох нь хэцүү гэдгийг хэлэх шаардлагагүй байхаа. Эдгээр бүлэгт гарах гол санаа эсвэл гол сэдэв бүрийг дурдах боломжгүй билээ. Харин бусдаасаа илүү чухалд тооцогдох хэдэн санааг онцгойлон авч үзэх боломжтой байдаг. Улмаар эдгээр гол сэдэв нь Аврахаамын амьдралын түүхийг бүрдүүлж байгааг бид харна. Мөн эдгээр нь анхны уншигч Израйльчуудаа Аврахаамын амьдралаас олж мэдээсэй гэж Мөшэхийн хүсэж байсан гол санаануудыг ойлгоход бидэнд туслана. Түүгээр ч барахгүй Библийн энэ хэсгээс Ертөнцийн Эзэн биднийг юу сураасай гэж хүсэж байгааг бид бас эдгээр гол сэдвээс олж харах болно.

Бид Аврахаамын амьдралын тухай өгүүлсэн хэсгийн гол сэдвүүдийг хоёр аргаар судлана. Эхлээд бид Аврахаамын амьдралын 4 гол сэдвийг танилцуулах түлхүүр ишлэлүүдийг судлана. Дараа нь бид энэ бүхэн Аврахаамын амьдралыг өгүүлсэн

бүлгүүдийн турш аажмаар ил болж байгааг үзэх болно. За эхлээд бүгдээрээ Аврахаамын түүхийн гол сэдвийг бидэнд танилцуулах түлхүүр ишлэлүүдийг үзэцгээе.

ТҮЛХҮҮР ИШЛЭЛҮҮД

Аврахаамын амьдралын түүхийн эхэн хэсэгт Ертөнцийн Эзэн түүнийг дуудаж байгаа тухай Эхлэлийн 12-р бүлгийн 1-3-т байдгийг та нар санаж байгаа байх. Аврахаамыг Месопотамийн Үүр хотод байхад нь Ертөнцийн Эзэн түүнийг Амласан нутаг руу яв гэж хэлдэг. Эдгээр ишлэл нь Аврахаамын амьдралын дэлгэрэнгүй түүхийн хувьд маш чухал санаа агуулж байгааг Библийн эрдэмтэд олон жилийн турш хүлээн зөвшөөрсөөр ирлээ. Энэ гурван ишлэлд Мөшэх юу гэж бичсэнийг одоо сонсоцгооё:

Нэгэн удаа Мөнхийн Эзэн Авраамд хандан, “Чи өөрийн болон эцгийнхээ ойр холын садан төрөл бүгдийг орхин нутгаасаа гарч миний зааж өгөх оронд очиж суурьшсугай. Би чамаас эхлэн өнөр өтгөн аугаа их улс бий болгож, чамайг баяр баясгалантай өөдрөг, нэр алдартай хүн болгож өгнө. Тийм учраас чамаас болж хожим нь бас олон хүнд баяр баясгалан ирнэ. Чамайг ерөөсөн хүнийг би ерөөнө. Харин чамайг хараасан хүнийг би хараана. Чамаар дамжуулан би орон бүхний ард түмнийг аз жаргалтай болгоно” гэж хэлсэн ажээ (Эхлэл 12:1-3).

Энэ гурван ишлэл нь маш чухал санааг агуулсан байдаг бөгөөд эдгээрийг олон янзын байдлаар хураангуйлж болох юм. Хэрэв эдгээр ишлэлийг хэлзүйн талаас нь хураангуйлъя гэвэл 1-р ишлэлийн эхний хэсэгт буй танилцуулгаас эхлэх болов уу. Тэгээд цааш нь Аврахаамд хэлсэн Ертөнцийн Эзэний үгийг хоёр хэсэг болгон үргэлжлүүлж үзнэ. Эхний хэсэг нь 1-р ишлэлийн сүүлийн хагасаас 2-р ишлэлийн ихэнх хэсгийг хамран орсон захирах хүсэх төлөвт буй бие даасан 3 үйл үгнээс бүрддэг. Аврахаамд хандан Ертөнцийн Эзэний хэлсэн үгийн хоёрдахь хэсэг нь 2-р ишлэлийн төгсгөлөөс 3-р ишлэлийг бүхэлд нь хамардаг. Энэ хоёрдахь хэсэг ч гэсэн эхнийхтэйгээ адил хэлзүйн бүтэцтэй байна. Дээрхтэй адил захирах хүсэх төлөвт буй бие даасан 3 үйл үг орсон байдаг. Эхлэлийн 12-р бүлгийн 1-ээс 3-т буй энэ гурван хэсгийг ажигласнаар бид эдгээр ишлэлийн утга учрын талаар зарим нэг маш чухал ойлголттой болж чадна.

Танилцуулга

1-р ишлэлд Аврахаамд хандан Ертөнцийн Эзэний хэлж буй үгийг тун энгийн байдлаар танилцуулж байгааг эхлээд сонсоцгооё:

Нэгэн удаа Мөнхийн Эзэн Авраамд хандан (Эхлэл 12:1).

Энэ мөрөнд буй үйл үгийг “Мөнхийн Эзэн . . . гэж хэлэв” бус “Мөнхийн Эзэн . . . гэж хэлсэн ажээ” хэмээн орчуулах нь зөв болохыг Библийн орчин үеийн хэдэн

орчуулга анзаарсан байдаг. Ингэж орчуулах нь маш чухал. Учир нь Үйл явдал номын 7-р бүлгийн 2-оос 4-т буй Стефаны хэлсэнээр бол, Аврахаам эцэг Тираахаа Хараан хотод нас барахаас өмнө Үүр хотод байхдаа Ертөнцийн Эзэний дуудлагыг хүлээн авсан ажээ. Харин бид Эхлэл номын үгчилэн бичсэн хэсгээс эхлээд 11-р бүлгийн 32-д Тираах нас барсан тухай уншаад, дараа нь 12-р бүлгийн 1-ээс Ертөнцийн Эзэн Аврахаамыг дуудаж байгаа олж мэддэг. Ийм шалтгааны улмаас л Эхлэлийн 12-р бүлгийн 1-д цаг хугацааны хувьд ухарч, өнгөрснийг эргэн дурсаж байгаа тул үүнийг “Мөнхийн Эзэн . . . гэж хэлсэн ажээ” хэмээн орчуулах ёстой юм. Тэгэхлээр энэ эхний хэсэг нь Аврахаамыг Ертөнцийн Эзэний дуудлагад хариу өгч Амласан нутаг уруу явахаас бүр өмнөх үеийг дурсан санасан юм байна.

Эхний хэсэг

Бид энэ танилцуулгын дараа Аврахаамд Ертөнцийн Эзэний хэлсэн үгийн эхний хэсгийг үзэх болно. Энэ эхний хэсэг нь тушаасан утгыг заасан захирах хүсэх төлөв буй үйл үгээр эхэлж байна. Бид Эхлэл номын 12-р бүлгийн 1-ээс:

Чи өөрийн болон эцгийнхээ ойр холын садан төрөл бүгдийг орхин нутгаасаа гарч миний зааж өгөх оронд очиж суурьшсугай (Эхлэл 12:1).

Энэ хэсэгт “орхи” гэсэн захиран тушаах хэлбэрт буй үйл үг байна. Үүнийг “Олон улсын шинэ орчуулга”-д “орхин яв” гэж утгачилан орчуулсан байдаг. Ертөнцийн Эзэн Аврахаамд ямар нэгэн юм хийхийг тушааж байна. Хинаан нутаг руу явахыг тушаав. Энэ бол Израйльчуудын хүндэт өвгөд Ертөнцийн Эзэний өгсөн анхны бөгөөд чухал тушаал байлаа.

Аврахаамд өгсөн Амласан нутаг руу яв гэдэг тушаалын дараа Ертөнцийн Эзэний түүнд хэлсэн үгийг 3 хувааж болно. Эдгээрийг 2-р ишлэлийн эхний хэсэгт буй бие даасан гурван үйл үг илэрхийлж байна. Эхлэлийн 12-р бүлгийн 2-ийг дахин үзье:

Би чамаас эхлэн өнөр өтгөн аугаа их улс бий болгож, чамайг баяр баясгалантай өөдрөг, нэр алдартай хүн болгож өгнө (Эхлэл 12:2).

Энэ хэсэг нь Аврахаамыг дуудахдаа Ертөнцийн Эзэний түүнд танилцуулсан ивээлүүд дээр голлон анхаарчээ. Нэгдүгээрт, Ертөнцийн Эзэн Аврахаамаас аугаа их улс бий болгоно гэсэн. Хоёрдугаарт, Тэрбээр Аврахаамыг баяр баясгалантай өөдрөг болгоно гэсэн бол гуравдугаарт, Аврахаам болон түүний удмыг алдартай хүмүүс болгоно гэж хэлсэн.

Хоёрдахь хэсэг

Одоо бүгдээрээ Аврахаамд хэлсэн Ертөнцийн Эзэний үгийн үлдсэн хэсгийг үзэцгээе. Хэдийгээр орчин үеийн ихэнх орчуулга бидэнд энэ бүгдийг харах боломж олгодоггүй ч Аврахаамд хэлсэн Ертөнцийн Эзэний үгийн хоёр дахь хэсэг нь хэлзүйн

хувьд эхний хэсэгтэйгээ зэрэгцээ хэлбэртэй байдаг. Эхний хэсэг нь захирах хүсэх төлөвт буй бие даасан гурван үйл үгээр эхэлдэг билээ. Бид Эхлэлийн 12-ийн 2-оос 3-т:

Тийм учраас чамаас болж хожим нь бас олон хүнд баяр баясгалан ирнэ. Чамайг ерөөсөн хүнийг би ерөөнө. Харин чамайг хараасан хүнийг би хараана. Чамаар дамжуулан би орон бүхний ард түмнийг аз жаргалтай болгоно (Эхлэл 12:2-3).

Энэ “Тийм учраас чамаас болж хожим нь олон хүнд баяр баясгалан ирнэ” гэдэг өгүүлбэрт орсон үйл үг нь Еврей хэл дээрээ захирах тушаах хэлбэрт байдаг бөгөөд эхний ишлэлд буй “орхи” гэсэн тушаах хэлбэрт буй үгтэй хоршиж байхаар хийгдсэн юм. Гэхдээ энэ захирах тушаах хэлбэрт буй үйл үг нь тушаал шиг утга агуулдаггүй. Үүнийг “Чи олон хүнд баяр баясгалан авчирна”, “Чи бусдад ивээл болно” эсвэл бүр “Чи бусдад зайлшгүй сайн сайхныг авчирна” гэж орчуулж болох юм. Аль ч утгаар нь авч үзсэн эдгээр захирах тушаах хэлбэртэй буй үгс нь бодол санааны маш чухал шилжилтийг харуулдаг. Энэ нь бидний анхаарлыг 2-р ишлэлийн эхний хэсгээс харсан сайн сайханыг хүлээн авсан Аврахаамаас бусдад энэ сайн сайхан бүхнээ дамжуулах суваг болж буй Аврахаам руу хандуулж байна.

Энэ хоёр дахь хэсэгт мөн л захирах хүсэх төлөвт буй бие даасан 3 үйл үг ордог. Эдгээр нь Аврахаамыг бусдад сайн сайхныг дамжуулах суваг болох үйл явцыг илэрхийлдэг. Нэгдүгээрт, Ертөнцийн Эзэн “Чамайг ерөөсөн хүнийг би ерөөнө” гэж хэлсэн. Энэ нь Аврахаамд нааштай хандсан хэнд ч Ертөнцийн Эзэн сайн сайхан зүйлийг хийж өгнө гэсэн үг юм. Хүмүүс Аврахаамд сайн хандвал Ертөнцийн Эзэн тэдэнд сайн хандана. Хоёрдугаарт, Ертөнцийн Эзэн “Чамайг хараасан хүнийг би хараана” гэж хэлсэн. Энэ нь Аврахаамыг үл тоомсорлосон хүнийг Ертөнцийн Эзэн хараана гэсэн үг юм. Аврахаамын дайсан болсон хүмүүст хатуу ширүүн хандаж хор хөнөөл учруулж түүнийг хамгаалах болно гэж Ертөнцийн Эзэн амласан билээ. Харин гуравдугаарт, Ертөнцийн Эзэн “Чамаар дамжуулан би орон бүхний ард түмнийг аз жаргалтай болгоно” гэсэн. Эхлээд харахад энэ гуравдахь хэсэг нь Аврахаамын дайснуудыг хараана гэсэн санаатай зөрчилдөж байгаа юм шиг санагддаг. Гэхдээ Ертөнцийн Эзэн Аврахаамын найз нарыг ивээх, дайснуудыг нь хараах энэ хоёр талт үйл явцын үр дүнд эцсийн эцэст орон бүхний ард түмнийг ивээж аз жаргалтай болгох ажээ. Тэгэхлээр бид Эхлэлийн 12-р бүлгийн эхний хэсгийн хэлзүй нь 3 гол зүйлд хуваагдаж байгааг үзлээ. Танилцуулга, Аврахаамд өгсөн Ертөнцийн Эзэний ивээл болон Аврахаамаар дамжуулан орон бүхний ард түмэнд Ертөнцийн Эзэний өгөх сайн сайхан бүхэнд анхаарлаа хандуулсан байна.

Эхлэл номонд буй Аврахаамын тухай түүх нь олон талаараа Аврахаамд өгсөн Ертөнцийн Эзэний энэ бүх амлалт түүний амьдралд хэрхэн биелэснийг харуулдаг учраас 12-р бүлэгт гарах эдгээр ишлэлийг ойлгох нь тун чухал юм. Мөшөх Аврахаамын тухай бичиж байхдаа энэ бүхнийг Ертөнцийн Эзэн Аврахаамыг Амласан нутаг явуулахаар дуудсан хэсэгт уншигчдынхаа анхаарлыг хандуулах зорилгоор бичсэн байна.

Тэгэхлээр бид энэ хэлзүйн бүтцийг сэтгэлдээ тээсэн цагтаа л Эхлэлийн 12-р бүлгийн 1-ээс 3-т Аврахаамын амьдралын тухай сэдвүүд хэрхэн ил болж байгааг

харахад бэлэн болдог юм.

ИЛ БОЛСОН ХЭСГҮҮД

Бид эдгээр ишлэлд 4 гол сэдэв харагдаж байгааг ажиглах болно. Бид Аврахаамд үзүүлсэн Ертөнцийн Эзэний хайр өршөөлийг эхлээд үзнэ. Дараа нь бид Ертөнцийн Эзэнд хандсан Аврахаамын үнэнч байдлын шалгуурыг үзнэ. Тэгээд Аврахаамд өгсөн Ертөнцийн Эзэний сайн сайхан зүйлсийг үзээд, эцэст нь Аврахаамаар дамжин ирэх Ертөнцийн Эзэний сайн сайхан зүйлсийг харах болно.

Ертөнцийн Эзэний хайр өршөөл

Эхний гол сэдэв нь Аврахаамын амьдралд олонтоо гардаг билээ. Учир нь Аврахаамтай харилцах Ертөнцийн Эзэний харилцаа нь Түүний хайр өршөөл дээр үндэслэж байлаа. Ертөнцийн Эзэний хайр өршөөл нь бидний сая үзсэн Эхлэлийн 12-р бүлгийн 1-д буй танилцуулгаас зурвасхан харагддаг. Тэндээс бид:

Нэгэн удаа Мөнхийн Эзэн Авраамд хандан. . . гэж хэлсэн ажээ (Эхлэл 12:1).

Энэ энгийн өгүүлбэр нь Мөшэхийн үгийг сонсож буй эхний уншигчдад Аврахаам Ертөнцийн Эзэнд үйлчилж эхлээс бүр өмнө Ертөнцийн Эзэн өөрөө Аврахаамын амьдралд орж ирж түүнтэй харилцаатай болсон гэдгийг сануулдаг.

Ертөнцийн Эзэн Аврахаамыг дөнгөж насанд хүрсэн үед нь дуудсан. Тэрбээр Хинаан орныг харахан зориогүй байлаа. Дайснуудаа ч ялаагүй байсан. Үнэнч шударгаар дагах гэрээ Ертөнцийн Эзэнтэй харахан байгуулаагүй байв. Сидом, Гомораах хотын гэмгүй хүний төлөө Ертөнцийн Эзэнээс гуйж амжаагүй байсан. Итгэлээ шалгуулах ямар ч сорилтонд ороогүй байлаа. Харин эсрэгээрээ, Аврахаамд энэрэнгүй хандах нь Ертөнцийн Эзэнд таалагдсан учраас л түүнийг өөрийнхөө тусгай үйлчлэлд дуудсан юм.

Мэдээж Ертөнцийн Эзэний хайр өршөөл нь зөвхөн Аврахаамыг Түүнтэй хамт алхаж эхэлсэн үед л харагдаагүй. Ертөнцийн Эзэний хайр өршөөл гэдэг санаа Аврахаамын тухай түүхийн турш гардаг. Учир нь Ертөнцийн Эзэн түүний амьдралын үе бүрд хайр өршөөлөө үзүүлж байсан юм. Аврахаам гэмт хүн учраас түүнд цаг үргэлж Ертөнцийн Эзэний өршөөл энэрэл хэрэгтэй байсан. Жишээлбэл, Библийн алдартай ишлэл болох Эхлэлийн 15-р бүлгийн 6-д Аврахаамыг гэм буруугүйд тооцсон үйлдэл нь Ертөнцийн Эзэний өршөөл энэрлийн бэлэг байсан тухай бид олж уншдаг. Тэр ишлэлд:

“[Аврахаам] Мөнхийн Эзэний . . . үгэнд чин сэтгэлээсээ итгэв. Үүнийх нь төлөө Мөнхийн Эзэн түүний бүх гэмийг уучлан, огт гэмгүйд тооцжээ (Эхлэл 15:6).

Есүсийн төлөөлөгч Пууль Ромын 4-р бүлгийн 3 болон Галатын 3-р бүлгийн 6-д Ертөнцийн Эзэн Аврахаамыг огт гэмгүйд тооцсон нь Түүний өршөөл энэрлээс болсон бөгөөд сайн үйлс бүтээснийх нь төлөө өгсөн шагнал байгаагүй гэж бичсэн байдаг. Ертөнцийн Эзэнээс Аврахаамын хүлээж авсан энэ болон бусад олон ивээл нь Түүний хайр өршөөлөөр дамжин ирсэн.

Бид Христэд итгэдгийнхээ хувьд Ертөнцийн Эзэний хайр өршөөл бидний амьдралд ямар чухал болохыг мэднэ. Ертөнцийн Эзэнтэй тогтоосон бидний харилцааг Тэрбээр хайр өршөөлөөрөө дамжуулан эхлүүлсэн гэдгийг бид мэднэ. Тэрбээр бидэнтэй тогтоосон энэ харилцаагаа хайр өршөөлөөрөө дамжуулан үргэлжлүүлдэг гэдгийг ч бид мэднэ. Ертөнцийн Эзэний хайр өршөөл байхгүй байсан бол бид хаана байх байсан бол? Аврахаамын хувьд ч гэсэн яг л ийм байсан. Түүгээр ч зогсохгүй Ертөнцийн Эзэний хайр өршөөл нь Аврахаамын тухай Мөшэхийн сануулан бичиж буй Израйльчуудын амьдралд бас чухал хэрэгтэй байлаа. Тэдний амьдралд ч гэсэн өдөр тутам, цаг тутам Ертөнцийн Эзэний өршөөл энэрэл хэрэгтэй байсан юм. Мөшэх Аврахаамын амьдралын түүхийг бичиж байхдаа тэдний анхаарлыг Ертөнцийн Эзэний хайр өршөөл руу дахин дахин хандуулж байсан нь ийм учиртай ажээ.

Аврахаамын үнэнч байдал

Бид Ертөнцийн Эзэний хайр өршөөлийн тухай сэдвээс гадна Эхлэлийн 12-р бүлгийн 1-д Аврахаамын үнэнч байдлын талаар бичсэн байдаг гэдгийг анхаарах ёстой. Ертөнцийн Эзэн Аврахаамыг зөвхөн Өөрийнх нь өршөөл энэрлийг хүлээн авахаар сонгоогүй юм. Тэрбээр Израйльчуудын энэ хүндэт өвөгт өршөөл энэрлээ үзүүлсэн учраас үүнд нь Аврахаам үнэнч дуулгавартай байдлаар хариулах ёстой байлаа. Бид Эхлэлийн 12-р бүлгийн 1-д захирах хүсэх төлөв буй эхний үйл үг нь зарим нэг тодорхой зүйл дээр Мөнхийн Эзэнд үнэнч байх Аврахаамын үүрэг хариуцлагыг онцолж байгааг харсан. Тэр ишлэлд Ертөнцийн Эзэн түүнд:

Чи өөрийн болон эцгийнхээ ойр холын садан төрөл бүгдийг орхин нутгаасаа гарч миний зааж өгөх оронд очиж суурьшсугай (Эхлэл 12:1).

Ертөнцийн Эзэний энэ дуудлага нь Аврахаамаас асар их үнэнч чанарыг шаардаж байсныг ойлгоход нэг их уран сэтгэмж хэрэггүй байх аа. Тэрбээр төрсөн нутаг, ааваасаа өвлөн ирэх эд хөрөнгөө орхиод, өөрөө ч үзэж амжаагүй газар нутар уруу зорьдог. Тийм ээ. Ертөнцийн Эзэн Аврахаамд өршөөл энэрлээ үзүүлсэн нь үнэн. Харин Аврахаам ч бас Ертөнцийн Эзэнд туйлын үнэнч гэдгээ харуулах ёстой байсан юм.

Харамсалтай нь Христэд итгэгч олон хүн Аврахаамыг зөвхөн Ертөнцийн Эзэнд итгэл найдвараа тавьсан хүний жишээ гэж боддог. Мэдээж энэ бол Аврахаамын амьдралаас харагдаж буй нэг гол санаа мөн бөгөөд энэ тухай Шинэ Гэрээний хэдэн хэсэгт онцлон бичсэн байдаг. Гэхдээ Ертөнцийн Эзэн Аврахаамд дуулгавартай байхыг тушааж, Өөрт нь үнэнч байх үйлчлэлийг өгсөн гэдэг баримтыг бид хайхрахгүй байж огт болохгүй. Ертөнцийн Эзэн Израйлийн алдартай энэ өвгөөс үнэнч байдлыг олон удаа шаардаж байсан. Тэрбээр ямар ч нөхцөл байдалд орсон Ертөнцийн Эзэнд найдвартай

үнэнч байдаг байв.

Ертөнцийн Эзэн Аврахаамаас Өөрт нь үнэнчээ харуулахыг шаардсан хамгийн их сэтгэл хөдлөм жишээ Эхлэлийн 22-р бүлэгт л байдаг байх. Энэ бол хүүгээсээ илүү Өөрт нь хайртай болохоо нотлохын тулд түүнээс хүү Яйцхаахаа өргөл болгохыг Ертөнцийн Эзэн тушаасан үе юм. Ертөнцийн Эзэн ийм хатуу шаардлага тавьсан гэж төсөөлөхөд ч бэрх байна.

Хэдийгээр Ертөнцийн Эзэн энэ болон өөр олон арга замаар Өөрт нь үнэнч болохоо харуулахыг Аврахаамаас шаардаж байсан ч Эхлэлийн 12-р бүлгийн 1-т Аврахаамын хүлээсэн хамгийн чухал үүрэг тодорхой харагддаг юм. Ертөнцийн Эзэн түүнд:

миний зааж өгөх оронд очиж суурьшсугай (Эхлэл 12:1).

Ертөнцийн Эзэн Аврахаамаас Өөрийнх нь зааж өгөх оронд очихыг шаардаж байсныг энэ хэсэг харуулж байна. Ингээд Аврахаам Ертөнцийн Эзэний амласан нутагт оршин суухаар болов. Түүний тухай өгүүлсэн түүхэнд ийм санаа олон гардаг. Аврахаам Амласан нутаг орон руу явах нь Аврахаамд болон түүний удам угсаанд зориулсан Ертөнцийн Эзэний том төлөвлөгөөний маш чухал хэсэг байлаа. Тэгэхлээр бусдыг Ертөнцийн Эзэний амласан нутаг руу өөрөө удирдан явж байсан Мөшэхийн бичсэн Аврахаамын тухай өгүүлсэн эдгээр түүхийг бид эргээд санавал ийм санааг онцолж байгаад нь нэг их гайхахгүй болов уу.

Хэдийгээр аврал нь Ертөнцийн Эзэний хайр өршөөлөөр дамжин бидэнд ирсэн үнэгүй бэлэг боловч, Түүний тушаалуудыг чадах чинээгээрээ дагаж л Түүнд талархаж байгаагаа илэрхийлэхийг Ертөнцийн Эзэн биднээс хүсэж байдаг гэдгийг бид Христийн дагалдагч хүнийхээ хувьд ойлгодог билээ. Энэ зарчмыг Мөшэх ч гэсэн сайн ойлгож байсан. Аврахаамд үзүүлсэн Ертөнцийн Эзэний хайр өршөөл түүнийг Ертөнцийн Эзэнд үнэнч байхад хүргэсэн гэдгийг Мөшэх мэдэж байлаа. Биднийг Аврахаамын амьдралыг судалж байхад үнэнч шударга байх шаардлага дахин дахин гарч ирдэг нь ийм учиртай юм. Өөрийнхөө анхны уншигч болох Израйльчуудын талаар Мөшэх нэг зүйлийг тун баттай мэдэж байлаа. Тэд Ертөнцийн Эзэний өмнө үнэнч амьдрах нь ямар чухал гэдгийг тун амархан мартчихдаг байв. Ертөнцийн Эзэн тэднийг Египетээс чөлөөлж, цөл хээр нутагт тэжээн тэтгэн Өөрийнхөө өршөөл энэрлийг харамгүй харуулж байсан ч тэд Түүний тушаалыг зөрчсөөр байлаа. Тийм учраас л Аврахаамын тухай түүхийн нэг гол санаа нь Аврахаамын Ертөнцийн Эзэнд үнэнч чанар юм. Мөшэхийн анхны уншигч болон өнөөгийн бид бүхэн Ертөнцийн Эзэний үгийг үнэнчээр дагах шаардлагатай учраас энэ санаа олон удаа гардаг.

Аврахаамд өгсөн сайн сайхан зүйлс

Ийнхүү бид Ертөнцийн Эзэн Аврахаамд хайр өршөөлөө харамгүй ихээр харуулж байсан шигээ Өөрт нь үнэнч шударгаар үйлчлэхийг шаардаж байсан тухай үзлээ. Эхлэлийн 12-р бүлгийн 1-ээс 3-т бидний анхаарвал зохих гурав дахь гол сэдэв бол Аврахаамд өгсөн сайн сайхан зүйлс юм Эхлэлийн 12-р бүлгийн 2-т Ертөнцийн Эзэн

Израйлийн энэ алдартай өвөгт:

Би чамаас эхлэн өнөр өтгөн аугаа их улс бий болгож, чамайг баяр баясгалантай өөдрөг, нэр алдартай хүн болгож өгн (Эхлэл 12:2).

Ертөнцийн Эзэн Аврахаамд 3 сайхан зүйлийг санал болгож байна. Давын өмнө Ертөнцийн Эзэн Аврахаамд өнөр өтгөн аугаа их улс бий болгож өгнө гэж хэлсэн. Түүний үр хүүхдүүд тоолж барамгүй олон болж, удам угсаанаас нь аугаа их эзэнт улс бий болох ажээ. Харин энэ үед Аврахаам болон түүнтэй хамт байсан хүмүүс тоо толгойн хувьд харьцангуй цөөхөн байлаа. Аврахаамд бүр өөрийн гэх үр хүүхэд ч байсангүй. Гэсэн хэдий ч нэгэн цагт Аврахаамын үр хүүхэд нь тэнгэрийн одноос ч олон болно гэж Ертөнцийн Эзэн амласан юм.

Хоёрдугаарт, Ертөнцийн Эзэн Аврахаамыг өөрийг нь ивээнэ гэж хэлсэн. Яаж ч бодсон энэ өгүүлбэр нь Аврахаам болон түүний удам угсаа асар их дэгжин дээшилнэ гэсэн утгатай байна. Аврахаам, мөн түүний удам угсаа нь элбэг дэлбэг амьдарч, эд хөрөнгөөр гачигдаж дутагдахгүй. Тэд дэлхий даяар хэрэн хэсүүчлэгчид эсвэл зөвхөн түр оршин суугчид байх ёсгүй ажээ. Аврахаам болон түүний хүүхдүүд үнэнч найдвартай гэдгээ нотлон харуулбал, тэд ихэд өөдлөн дэвжих байв.

Гуравдугаарт, Ертөнцийн Эзэний энэ бүх ивээл нь Аврахаамыг аугаа их нэр хүндтэй болгох ажээ. Өөрөөр хэлбэл, Аврахаам Амласан нутаг руу явж Ертөнцийн Эзэнд үнэнч байж чадвал түүний үр сад үй олон болж, асар их өөдлөн дэмжих бөгөөд ингэснээр түүнийг дэлхий даяар нэр алдартай хүн болох байлаа. Энэ агуу өвөг болон түүний үр удамд асар их алдар хүнд ирэх байв.

Үнэнийг хэлэхэд Аврахаамын тухай өгүүлсэн түүхийнхээ туршид дээр дурдсан бүх сайн сайхан зүйл Аврахаамд цутган ирсэн юм хэмээн Мөшэх дахин дахин онцолж байсан билээ. Тэрбээр нэг үйл явдлаас нөгөөд оролцож явахдаа үр хүүхэд, эд баялагтай болж байв. Нутаг орондоо алдартай хүн болов. Энэ бүх түүхийг Израйльчууд сонсоод Аврахаамын хүртэж байсан сайн сайхан бүхэн тэдэнд ирээдүйд ч бас ирнэ гэсэн агуу их итгэл найдварыг авдаг байлаа. Аврахаамд өгсөн үр хүүхэд, эд хөрөнгө, алдар нэр бол түүний үнэнч удам угсаанд Ертөнцийн Эзэний өгөх агуу их бэлгийн урьдчилсан дохио төдий л зүйл байсан юм.

Христэд итгэгч бид Ертөнцийн Эзэнээс маш олон сайн сайхан зүйл хүлээж авсан билээ. Бид тэр бүгдийг нэг бүрчлэн нэрлэж ч чадахгүй байх. Мэдээж Мөшэхийг дагаж Амласан нутаг руу явсан Израйльчууд хүртэл Ертөнцийн Эзэний маш олон сайн сайхан зүйлийг хүлээн авсан. Тэд боолчлолоос чөлөөлөгдөж, өсөж үржсэн. Тэд мөн бүхий л аян замын турш хамгаалагдаж, тэжээн тэтгүүлж байв. Тэд ирээдүйд агуу их сайн зүйлийг өгөх нутаг болох амлалтын нутаг руу явж байлаа. Гэхдээ Израйльчууд бидэнтэй адилхан хүмүүс байсан. Тэд өөрсдийнх нь төлөө Ертөнцийн Эзэний хийсэн бүгдийг, мөн ирээдүйд тэдэнд зориулж хадгалсан бүгдийг тун амархан мартаж байв. Тиймээс Мөшэх анхныхаа уншигчид болох Израйльчуудад Ертөнцийн Эзэний ивээлүүдийг сануулахын тулд Аврахаамд үзүүлж байсан Түүний ивээлийн тухай бичсэн бөгөөд тэд тэр бүхэнд талархаж байх ёстой байв.

Аврахаамаар дамжин ирэх сайн сайхан зүйлс

Эхлэлийн 12-ийн 1-ээс 3-д Ертөнцийн Эзэний хайр өршөөл, Аврахаамын үнэнч байдал болон түүнд үзүүлсэн Ертөнцийн Эзэний ивээлээс гадна Аврахаамаар дамжин бусад хүмүүст ирэх сайн сайхан зүйлс бидний анхаарлыг татдаг юм. Ертөнцийн Эзэн Эхлэлийн 12-ийн 2, 3-р ишлэлд:

чамаас болж хожим нь бас олон хүнд баяр баясгалан ирнэ. Чамайг ерөөсөн хүнийг би ерөөнө. Харин чамайг хараасан хүнийг би хараана. Чамаар дамжуулан би орон бүхний ард түмнийг аз жаргалтай болгоно (Эхлэл 12:2-3).

Энэ ишлэл нь Аврахаам Ертөнцийн Эзэний ивээлийг хүлээж авахаас гадна түүгээр дамжин орон бүхний ард түмэн ивээгдэнэ гэдгийг тайлбарласан байна. Ертөнцийн Эзэн Аврахаамыг зөвхөн Амласан нутагт аваачих гэж, түүнийг болон түүний үр удмыг баян тарган амьдруулах гэж дуудаагүй. Ертөнцийн Эзэн Аврахаамыг энэ дэлхийн бүх гэр бүлд Өөрийнхөө ивээлийг хүргэх суваг болгох гэж дуудсан юм. Тэгэхлээр энэ хэсэг Аврахаамын дэлхий дахиныг хамрах ивээл 2 арга замаар ирнэ гэж зааж байгааг бид санах нь чухал. Эхлэлийн 12-ийн 3-т:

Чамайг ерөөсөн хүнийг би ерөөнө. Харин чамайг хараасан хүнийг би хараана (Эхлэл 12:3).

Энд бичсэнээр бол Аврахаам хүн төрөлхтний дунд хоёр талдаа иртэй сэлэм шиг л үүрэг гүйцэтгэж байна. Учир нь Аврахаам Ертөнцийн Эзэний хайр хишгийг хүртсэн учраас бусад улс орны хүмүүс Аврахаамыг ивээвэл, түүнийг хүндэлбэл түүний үйлчилж буй Ертөнцийн Эзэнийг хүндэлж байгаа тул Ертөнцийн Эзэн тэднийг ивээх ажээ. Харин бусад улс орны хүмүүс Аврахаамыг хараах юм уу, түүнд халдан довтолбол түүний дээдлэн хүндэлдэг Ертөнцийн Эзэнийг үл тоомсорлосон хэрэг тул Ертөнцийн Эзэн тэднийг шийтгэх болно. Тэгэхлээр бусад хүмүүсийн хувь заяа Аврахаамд хэрхэн хандсанаас шалтгаалж байна.

Аврахаам амьдралынхаа турш Пилэшэт, Хинаан, Египет үндэстэн болон ач хүү Лоот өвөг дээдэс нь болсон Муаб, Аммун овог аймгийн хүмүүстэй уулзаж учирч байлаа. Эдгээр харилцаа нь Ертөнцийн Эзэн бусад хүмүүсийг Аврахаамд хэрхэн хандаж байснаар нь ерөөнө эсвэл хараана гэж хэлсэн үгэндээ хүрч байсан эсэхийг тусгайлан харуулах учраас чухал ач холбогдолтой юм. Энэ нь мөн Аврахаам энэ дэлхийд амьдарч байхдаа л хүмүүст Ертөнцийн Эзэний ивээлийг дамжуулж эхэлснийг харуулдаг.

Гэвч Ертөнцийн Эзэний хүмүүс энэ чухал сургамжийг амархан мартаж олонтоо тохиолддог. Мөшэхийн үед амьдарч байсан Израйльчууд нь өнөө цагийн Христэд итгэгч олон хүнтэй их адилхан байлаа. Бид Ертөнцийн Эзэний аврал, Түүний өгсөн амьдралд баярлан хөөрдөг ч яагаад энэ бүх ивээлийг бидний хүн нэг бүрд өгсөн болохыг мартдаг билээ. Мөшэхийн удирдлагад буй Израйльчуудад өгсөн Ертөнцийн Эзэний ивээл бүр, өнөөгийн Христийн сүмд өгсөн Түүний ивээл бүр агуу их нэг л

зорилготой байдаг юм. Бид Ертөнцийн Эзэнээс сайн сайхан зүйлийг хүртсэн. Тэгээд Ертөнцийн Эзэний энэ бүх ивээлийг хүн төрөлхтөнд тараах ёстой юм. Ертөнцийн Эзэн Аврахаамыг өөртөө дуудсан. Тиймээс Аврахаам дэлхийн улс үндэстэнүүдийг Ертөнцийн Эзэний ивээл руу хөтлөн аваачих ёстой байв. Мөшэхийн үед Ертөнцийн Эзэн Израйльчуудыг өөртөө дуудсан бөгөөд тэд дэлхийн улс үндэстэнүүдийг Ертөнцийн Эзэний ивээлд удирдан аваачих ёстой байлаа. Ертөнцийн Эзэн өнөөгийн Христэд итгэгчдийг өөртөө дуудсан бөгөөд бид энэ дэлхийн улс үндэстэнүүдийг Ертөнцийн Эзэний ивээлд хөтлөн аваачих ёстой юм. Энэ санаа Аврахаамын тухай түүхийг анх хүлээн авсан Израйльчуудад туйлын чухал байсан шигээ өнөө үед Христийг дагаж буй бид бүхэнд ч бас чухал байдаг юм.

ДҮГНЭЛТ

Бид энэ хичээлээр Аврахаамын амьдралын тоймын эхний судалгааг хийлээ. Эхлэл номын энэ хэсгийн бүтэц болон зохиомж дээр анхаарлаа хандуулсан. Бид бас утга зохиолын ийм бүтцийн хүрээнд Аврахаамын амьдралын талаар Мөшэхийн танилцуулсан гол сэдэв буюу санаа болон агуулгыг судлалаа.

Бид эдгээр цуврал хичээлийг үзэж байхдаа энэ хичээлийн гол сэдэв руу дахин дахин ирэх болно. Бид Аврахаамын амьдралын түүх нь 5 тэнцвэртэй үе шатаас бүрддэгийг үзсэн. Аврахаамын амьдралд 4 гол санаа буюу сэдэв гарч байгааг ч бид үзсэн. Эдгээр нь Аврахаамд үзүүлсэн Ертөнцийн Эзэний сайн сайхан сэтгэл, Аврахаамын үнэнч байдал, Аврахаамд өгсөн Ертөнцийн Эзэний сайн сайхан зүйлс болон Аврахаамаар дамжин ирэх Ертөнцийн Эзэний сайн сайхан зүйлс юм. Эдгээр сэдэв нь Аврахаамын амьдралын түүх Израйльчуудад зориулж анх бичигдэхдээ ямар утга агуулж байсныг бидэнд ойлгуулаад зогсохгүй, библийн энэ хэсгийг өнөөгийн бидний амьдралд хэрэгжүүлэх боломжтой болгож байна.

Др. Ричард Л. Прагт. (Host) is Co-Founder and President of Third Millennium Ministries. He served as Professor of Old Testament at Reformed Theological Seminary for more than 20 years and was chair of the Old Testament department. An ordained minister, Dr. Pratt travels extensively to evangelize and teach. He studied at Westminster Theological Seminary, received his M.Div. from Union Theological Seminary, and earned his Th.D. in Old Testament Studies from Harvard University. Dr. Pratt is the general editor of the NIV Spirit of the Reformation Study Bible and a translator for the New Living Translation. He has also authored numerous articles and books, including *Pray with Your Eyes Open, Every Thought Captive, Designed for Dignity, He Gave Us Stories, Commentary on 1 & 2 Chronicles* and *Commentary on 1 & 2 Corinthians*.

ҮГСҮЙН ТАЙЛБАР

Аби-Мэлэх (Abimelech) – Негев нутгийн Герар хотын хаан. Тэрээр Сарахыг Аврахамын дүү охин гэж итгээд өөртөө авахыг оролдсон

Аврам (Abram) – Аврахамын төрөлх нэр

Хинаан нутаг (Canaan, land of) – Ертөнцийн Эзэнтэй байгуулсан гэрээний дагуу Аврахам болон түүний үр удамд өгөгдөхөөр амласан нутаг. Өнөөгийн Израил улсын нутаг дэвсгэр болон Палестиний нутаг, Ливи, Иордан, болон Газар дундын эргийн дагуу нутаг мөн Египет Сирийн зарим хэсэг энд багтдаг

гэрээ (covenant) – Хоёр хүн эсвэл бүлэг хүмүүсийн хооронд, мөн Бурхан аливаа хүн ба бүлэг хүмүүстэй байгуулсан заавал биелүүлэх үүрэг бүхий хууль ёсны хэлцэл

урьдчилсан дохио (foreshadow) – Түүхэнд ирээдүйд гарцаагүй болох үйл явдлыг өнөөдөр урдчилан дүрсэлж буй уран зохиолын арга барил

Хагаар (Hagar) – Сарахын шивэгчин бүсгүй. Тэрээр Аврахаамтай унтаж Яйшмагийг төрүүлсэн

Яйцхаах (Isaac) – Аврахаам Сараах хоёрын хүү. Ертөнцийн Эзэний гэрээний амлалтыг өв залгамжлагч.

Яйшмагийл (Ishmael) – Аврахаам Хагаар хоёрын хүү.

Лоот (Lot) – Аврахаамын ач дүү.

Негев (Negev) – Хинааны өмнө зүгт орших цөл нутаг.

Сараах (Sarah) – Аврахаамын эхнэр. Төрөлхи нэр нь Сарай. Өтөлсөн хойноо Яйцхаахыг төрүүлсэн.

Сидом (Sodom) – Ертөнцийн Эзэн тэнгэрээс хүхэрт гал буулган устгасан гэмт хот.

Тираах (Terah) – Аврахамын аав.

толодом (toledot/toledoth) – “Үеүүд” гэсэн утгатай Еврей үг